# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (394)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хүүхдийн төлөө сангийн дүрэм батлах тухай*
- *Үндэсний хөтөлбөр батлах тухай ("Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөр)*
- *Тооны дээд хязгаар тогтоох тухай*
- *Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2005 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2005 оны дөрөвдүгээр сарын 7 | №13 (394)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 639. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 38 | 290 |
| 640. | Хундангийн Чапаевт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 39 | 294 |
| 641. | Дипломат цол олгох тухай | Дугаар 40 | 295 |
| 642. | Дипломат цол олгох тухай | Дугаар 41 | 295 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 643. | Хүүхдийн төлөө сангийн дүрэм батлах тухай | Дугаар 40 | 295 |
| 644. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 41 | 297 |
| 645. | Нэрэмжит болгох тухай | Дугаар 42 | 297 |
| 646. | Үндэсний хөтөлбөр батлах тухай ("Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөр) | Дугаар 43 | 297 |
| 647. | Усны хэрэг эрхлэх газар байгуулах тухай | Дугаар 46 | 306 |
| 648. | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 48 | 306 |
| 649. | Элчин сайдын яаманд газар нэмж ашиглуулах тухай | Дугаар 49 | 307 |
| 650. | Элчин сайдын яаманд газар нэмж ашиглуулах тухай | Дугаар 50 | 307 |
| 651. | Тооны дээд хязгаар тогтоох тухай | Дугаар 51 | 308 |
| 652. | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай | Дугаар 52 | 308 |
| 653. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 55 | 309 |
| 654. | Ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 56 | 309 |
| 655. | Ажилд томилох тухай | Дугаар 57 | 309 |
| 656. | Ажилд томилох тухай | Дугаар 58 | 309 |
| 657. | Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө *(Үргэлжлэл)* | Дугаар 245 | 310 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, банк, хэвлэл мэдээлэл, зэвсэгт хүчин, шүүх, цагдаа, төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**Сүхбаатарын одонгоор:**

Лувсангомбын Моломжамц-БХЯ-ны дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал, бэлтгэл дэслэгч генерал

**Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:**

1. Осорын Бямбаа- Барилгын цэргийн 182 дугаар ангийн захирагч, хурандаа

2. Готовын Лүндэн- БХЯ-ны Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны газрын ажилтан, хурандаа

**Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор:**

1. Батбуянгийн Бат-Эрдэнэ - Цагдаагийн академийн сургалт эрхэлсэн дэд захирал, цагдаагийн хурандаа

2. Гочоогийн Бүлтэн- БХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академийн багш, хурандаа

3. Жамсранжавын Ванчинсүрэн-ЗХЖШ-ын Артиллерийн цэргийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа

4. Чойдогийн Дашдэлэг- ЗХЖШ-ын Ар талын газрын материал хангалтын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

5. Сандагжавын Лхасүрэн- ЗХЖШ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

6. Доржийн Отгонбаатар- ЗХ-ний 124 дүгээр ангийн захирагч, хурандаа

7. Дашийн Төмөрбаатар- Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

8. Майдарын Төмөрбаатар- Барилгын цэргийн 017 дугаар ангийн захирагч, хурандаа

9. Зундуйн Чулуундорж- БХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академийн дэд захирал, хурандаа

10. Гомбосүрэнгийн Янжив- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын ахлах офицер, хурандаа

**"Алтан гадас" одонгоор:**

1. Руламын Авирмэд- Өмнөговь аймгийн Шүүхийн давж заалдах шатны шүүгч

2. Цэдэндоржийн Алтанцэцэг-Төр, засгийн үйлчилгээний авто баазын диспетчер

3. Ыбырайн Аралхан- Баян-Өлгий аймаг дахь Багшийн коллежийн багш

4. Мижиддоржийн Баасанжав- Нийслэлийн Баянгол дүүргийн 77 дугаар цэцэрлэгийн багш

5. Цэвэгмэдийн Бадамсүрэн- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн халдвар судлагч их эмч

6. Жамбалсүрэнгийн Батбилэг- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

7. Дэмчигийн Батболд- Орхон аймгийн Жаргалант сум дахь хөдөө аж ахуйн "Талын нуур" ХХК-ийн захирал

8. Гомбодоржийн Батхүрэл- ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн захирал

9. Лувсангийн Баяраа- Сэлэнгэ аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

10. Гунгаагийн Баясгалан - Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх

11. Данзандоржийн Баясгалан- Голомт банкны ерөнхий захирал

12. Женисханы Бигаан- Баян-Өлгий аймаг дахь Багшийн коллежийн сургалтын албаны дарга

13. Долгорын Буниамаа- Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн зөвлөх эмч

14. Авирмэдийн Буянхишиг- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Өрнөлт-Од" ХХК-ийн ерөнхий захирал

15. Цэнд-Аюушийн Ганболд-Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвийн ерөнхий санхүүч

16. Нацагдоржийн Гантөмөр- Бурхан шашинт эмэгтэйчүүдийн "Төгс баясгалант" төвийн тэргүүн

17. Очирбатын Гэрэл- Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн

18. Таягийн Даваажав- Монгол Улсын Засгийн газрын референт

19. Бэгзсүрэнгийн Дангаасүрэн - БСШУЯ-ны харъяа Мэргэжил арга зүйн төв 29 дүгээр тусгай сургуулийн сонсгол засал судлалын их эмч

20. Чойнжуурын Должинсүрэн - Нийслэлийн Баянгол дүүрэг дэх "Билиг- Оюу" хувийн дунд сургуулийн сургалтын менежер

21. Навааншаравын Доржцэрэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэн, ахмад багш, хүүхдийн зохиолч

22. Түндэвийн Дулмаа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн нэгдүгээр дунд сургуулийн гадаад хэлний багш

23. Очирхүүгийн Жаргалсайхан- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

24. Цэдэвийн Нэргүй- ЗХ-ний 336 дугаар ангийн орон сууцны ашиглалтын хэсгийн дарга

25. Жигмэдийн Нямцэнгэл- Улсын Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн хүүхдийн тасгийн сувилагч

26. Мөнхцэрэнгийн Оюунбилэг- Нийслэлийн нийтийн аж ахуйн үйлчилгээний "Түшиг-Сайхан" ХХК-ийн захирал

27. Нацагдоржийн Оюунчимэг- Говьсүмбэр аймгийн Шүүхийн шүүгч

28. Мийдрээгийн Өлзийтогтох- Сэргээгдэх эрчим хүчний шинжлэх ухаан үйлдвэрлэлийн нэгдлийн салбарын эрхлэгч

29. Сайдын Өнөр- Нийслэлийн Налайх дүүргийн Шүүхийн шүүгч

30. Дашсамбуугийн Полоож - Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга

31. Цамбасүрэнгийн Пүрэвдорж - Улсын Их Хурлын Тамгын газрын хуралдаан зохион байгуулах албаны дарга

32. Равдангийн Пүрэвсүрэн- Нийслэлийн газрын тосны "Тас Петролеум" ХХК-ийн ерөнхий захирал

33. Дамдингийн Рэнцэнноров- Нийслэлийн хөдөө аж ахуйн "Агротех-импекс" ХК-ийн мэргэжилтэн

34. Буянтын Сайжрах- Нийслэлийн мэдээлэл, сургалт, мэргэжил сурталчилах "Итгэлт-Оюу" төвийн удирдлагын зөвлөлийн дарга

35. Торпахын Торгууд- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 10 жилийн дунд сургуулийн нийгмийн ажилтан

36. Иманханы Төлөөгөн- Ховд аймгийн Буянт сумын ногоочин

37. Дүгэрийн Тунгалаг- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нэгдүгээр 10 жилийн сургуулийн монгол хэлний багш

38. Бальдирмаагийн Жадбаатар- Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн засварчин

39. Мухышын Хайса- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын 10 жилийн сургуулийн хими, биологийн багш

40. Данзанноровын Хүү- МУБИС-ийн Багшийн сургуулийн тэнхмийн эрхлэгч

41. Чалхаагийн Цэрэнжав- Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Цог бэйс" хоршооны эзэн

42. Төмөрбаатарын Цэрэнлхам- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Алтан жолоо трейд " ХХК-ийн аж ахуйн нярав

43. Чулууны Цэрэнпагма- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 108 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

44. Уртнасангийн Цэрэнханд- Нийслэлийн барилгын сантехник, салхивч, автоматик, угсралт үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн ажилчин

45. МөнхөөгийнЧимэгмөнх- Голомт банкны санхүүгийн мэдээлэл, хяналтын газрын захирал

46. Дэлгэрийн Чүлтэм- Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Барилгын хийц эдлэлийн үйлдвэрийн дарга

47. Ганболдын Эрхэмбаяр- Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

**Цэргийн гавьяаны одонгоор:**

1. Лувсангийн Амгалан- Замын цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны хэлтсийн ерөнхий жижүүр, цагдаагийн дэд хурандаа

2. Жамьянгийн Батнасан- БХЯ, ЗХЖШ-ын үйлчилгээ аж ахуйн хэлтсийн дарга, дэд хурандаа

3. Тойнхүүгийн Баярмагнай- ЗХЖШ-ын Цэргийн тагнуулын газрын мэргэжилтэн, хурандаа

4. Лхагвын Дагва- ЗХ-ний 124 дүгээр ангийн 143 дугаар салбарын захирагч, хошууч

5. Рэгжийбуугийн Дагдан- ЗХ-ний 189 дүгээр ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа

6. Жумбаагийн Дарвин- ЗХ-ний 124 дүгээр ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, хошууч

7. Балданхүүгийн Лхагвасүрэн- Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

8. Ванчингийн Лувсанпүрэв- ЗХ-ний 325 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

9. Маналжавын Мөнх-Очир - ЗХ-ний 013 дугаар ангийн штабын даргын орлогч, дайчилгааны офицер, дэд хурандаа

10. Пүрэвийн Өлзий- ЗХ-ний Барилгын цэргийн газрын дэд дарга, ерөнхий менежер, хурандаа

11. ЛувсандоржийнПүрэвдорж - ЗХ-ний 015 дугаар ангийн тохируулгын техникч жолооч, ахлах ахлагч

12. Ванчингийн Самбуу- Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа

13. Мөнхтөрийн Санжаа- Замын цагдаагийн газрын Баянзүрх дүүргийн замын цагдаагийн тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

14. Гомбын Сумъяа- БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн автын тэнхмийн дарга, хурандаа

15. Гүрсэдийн Сүхбаатар- ЗХ-ний 120 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, хурандаа

16. Монтойн Хүрлээ- БХЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга, хурандаа

17. Чойжилжавын Хүрэлбаатар- ЗХ-ний 150 дугаар ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

18. Цэндийн Чимэддорж- ЗХ-ний 303 дугаар ангийн онгоц, нисдэг тэрэгний үйлчилгээний бүлгийн дарга, хошууч

19. Жамцдоржийн Энх-Амгалан - ЗХ-ний 167 дугаар ангийн зэвсгийн дарга, дэд хурандаа

**Хөдөлмөрийн хүндэт медалиар:**

1. Бат-Очирын Алтанцэцэг- Нийслэлийн гадаад хэлний сургалтын "Абука" ХХК-ийн захирал

2. Моонongийн Алтанцэцэг- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш

3. Баянтунгалагийн Ариунгуа- Голомт банкны төлбөр тооцооны хэлтсийн нягтлан бодогч

4. Мягмаржавын Баасанхүү- Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин

5. Лувсаншаравын Бааяа- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш

6. Дугарын Бат-Очир- Нийслэлийн хүнс, барилга, үйлдвэрлэлийн "Холбоо –Ус" ХХК-ийн захирал

7. Лавдангийн Бат-Өлзий- Барилгын цэргийн "Багабаян" амралтын газрын нягтлан бодогч

8. Чимэдрэгзэнгийн Баттөмөр- Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мастер багш

9. Шагдарын Буманноров- ЗХ-ний 189 дүгээр ангийн сүлжээний техникч

10. Бибишийн Буянтогтох- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн сургалтын менежер

11. Пүрэвийн Бямбадорж- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Шүүхийн шүүгч

12. Гэжээгийн Галя- ЗХ-ний 016 дугаар ангийн хүн эмнэлгийн физик эмчилгээний боолтын сувилагч

13. Лхасүрэнгийн Ганболд- Улсын геодези, зураг зүйн "Аэрогеодези" ХК-ийн ахлах техникч-жолооч

14. Дашнямын Гүнжидмаа- Рашаан судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч

15. Пүрэвийн Дондолсүрэн - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн ажилтан

16. Товуугийн Дугар -Сүхбаатар аймгийн Асгат сумын Их-Уул багийн малчин

17. Чойдонгийн Дулмаа- Увс аймгийн Шүүхийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

18. Моломын Жавзандорж- ЗХ-ний 013 дугаар ангийн тогооч

19. Содномдоржийн Лхамсүрэн- Дорноговь аймгийн Шүүхийн нягтлан бодогч

20. Даваахүүгийн Мөнхтуул- Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

21. Магнайн Мягмарсүрэн- Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч

22. Хизатын Наримхан- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ахлах сургуулийн багш

23. Мустафагийн Нурзия- Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентген техникч

24. Сэнгээгийн Очирбат- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 87 дугаар сургуулийн орос хэлний багш

25. Банзрагчийн Пунцаг- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга

26. Тавхийн Сайнжаргал- БХЯ-ны Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны дарга, дэд хурандаа

27. Намсрайн Сандагдулам- Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын үйлчлэгч

28. Хуандагийн Сауле- Нийслэлийн Налайх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн төрөх тасгийн эрхлэгч

29. Дэмчигийн Сономбал- Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын 2 дугаар шүүхийн бичээч, нярав

30. Мэндийн Сэртэв- Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёлын газрын арга зүйч

31. Яайгийн Съезд- Баян-Өлгий аймаг дахь Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга

32. Хабайханы Тохор- Баян-Өлгий аймгийн Толбо сумын 10 жилийн дунд сургуулийн сургалтын менежер

33. Шадравын Төгсгэрэл- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Шүүхийн шүүгч

34. ЦэдэвийнТуяа- Нийслэлийн Баянгол дүүргийн Шүүхийн шүүгч

35. Нурмагийн Уатхан- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4 дүгээр 10 жилийн дунд сургуулийн бага ангийн багш

36. Юндэндоржийн Уранчимэг- Өвөрхангай аймгийн Богд сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч

37. Бөкейн Хамар- Баян-Өлгий аймгийн Хэвлэл мэдээллийн төвийн радиогийн нэвтрүүлэгч

38. Намхайн Цогоо- Дорнод аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

39. Долдойн Цэрэг- Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн

40. Цэдэндашийн Цэрэнпагма - ЗХ-ний 027 дугаар ангийн хүний их эмч

41. Доржийн Чимчигнамхай- Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэгийн заах арга зүйч багш

42. Дашзэвэгийн Энхжаргал - Завхан аймгийн Шүүхийн Тамгын хэлтсийн дарга

**Цэргийн хүндэт медалиар:**

1.Тувааны Алтантулга- Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын дуучин, ахлах ахлагч

2. Дамдинжавын Бадрал- Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн инженер техникийн албаны дарга, дэд хурандаа

3. Бяруузаныи Балдан- ЗХ-ний 186 дугаар ангийн кино, радио механикч, жолооч, ахлах ахлагч

4. Цэнд-АюушийнБатаа- ЗХ-ний 336 дугаар ангийн тагнуулын техник хадгалах тасгийн дарга, хошууч

5. Бадарчийн Батжаргал - Замын цагдаагийн газрын хамгаалалтын тасгийн зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч

6. Түвдэнгийн Батзориг- ЗХ-ний 123 дугаар ангийн артиллерийн тагнуулын дарга, хошууч

7. Борын Бат-Эрдэнэ- ЗХ-ний 337 дугаар ангийн радио, цахилгаан тоноглолын инженер, хошууч

8. Надмидын Баярсайхан - ЗХ-ний 016 дугаар ангийн кино механикч, ахлах ахлагч

9. Содномын Болдбаатар - ЗХ-ний 015 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа

10. Нацагийн Бор - БХИС-ийн харуулын ротын салааны захирагч, ахмад

11. Батнасангийн Буд- БХИС-ийн орон сууц, үйлчилгээний тасгийн дарга, дэд хурандаа

12. Шоовдорын Буяндэлгэр - БХИС-ийн харуулын ротын захирагч, хошууч

13. Дагвасүрэнгийн Бямбацогт - ЗХ-ний 256 дугаар ангийн авто тээврийн салааны жолооч, ахлах ахлагч

14. Батменхийн Бямбацэрэн - БХИС-ийн нууцын дарга, дэд хурандаа

15. Содномдаржаагийн Дагдан - Замын цагдаагийн газрын Сонгинохайрхан дүүргийн замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч

16. Готовын Дорждагва - Барилгын цэргийн 017 дугаар батальоны өрөгч-угсрагчийн бүлгийн дарга, ахлах ахлагч

17. Шархүүгийн Дулмаа - ЗХЖШ-ын Цэргийн тагнуулын газрын нууцын дарга, ахмад

18. Ичинхорлоогийн Мөнхбаяр - ЗХ-ний 167 дугаар ангийн засварын техник хадгалах тасгийн дарга, хошууч

19. Чойрогийн Наранбадрах- ЗХ-ний 014 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

20. Жадамбын Нармандах - Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын нөхөн хангалт, тоо бүртгэл хариуцсан офицер, хошууч

21. Аюушийн Нямжав - ЗХ-ний Барилгын цэргийн газрын нууцын дарга, ахлах ахлагч

22. Дагвын Нямсүрэн - ЗХЖШ-ын Ар талын газрын барилга, орон сууцны хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

23. Бямбаражийн Очхүү- ЗХ-ний 120 дугаар ангийн хүнсний дарга, дэд хурандаа

24. Дэлэгнямын Пүрэвбаатар - ЗХ-ний 186 дугаар ангийн ар талын даргын орлогч, дэд хурандаа

25. Жанчивын Сумъяа- ЗХ-ний 256 дугаар ангийн ар талын даргын орлогч, дэд хурандаа

26. Батсүхийн Сүхбаатар - ЗХ-ний 337 дугаар ангийн жагсаал ангийн дарга, ахлах ахлагч

27. Рэнцэндоржийн Туяа- Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин, ахлах ахлагч

28. Гомбосүрэнгийн Хажидсүрэн - БХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академийн нууцын дарга, ахлах ахлагч

29. Гүрдагвын Цэрэнлхам- Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн жагсаал ангийн дарга, ахлах ахлагч

30. Гүнсэнхорлоогийн Чулуунбаатар - ЗХ-ний Клиникийн төв госпиталийн дотрын клиникийн удирдагч, ахлах эмч, дэд хурандаа

31. Доржсүрэнгийн Энхбаяр- ЗХ-ний 016 дугаар ангийн инженерийн албаны дарга, хошууч

32. Магсарын Энхбаяр - Барилгын цэргийн 030 дугаар ангийн барилгын инженер, хошууч

33. Дорждэгдийн Энхболд -Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

34. Гомбосүрэнгийн Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн аккумлятор засварлах, хадгалах тасгийн дарга, хошууч

35. Түгийн Эрдэнэбямба- ЗХ-ний 284 дүгээр ангийн цэргийн байр зүйн зургийн төв агуулахын дарга, дэд хурандаа

36. Аюушийн Эрдэнэчулуун- ЗХ-ний 123 дугаар ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

37. Далайн Юра- ЗХ-ний 014 дүгээр ангийн галт хэрэгслийн инженер, хошууч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 3 дугаар сарын 22-ны өдөр** | **Дугаар 39** | **Улаанбаатар хот**

**Хундангийн Чапаевт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж ардын уламжлалт хөгжмүүдийг сайн эзэмшиж, олон дууг чадварлаг дуулж, жүжгийн гол туслах дүрүүд бүтээж, төв, хөдөөгийн иргэдэд урлагаар үйлчлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин, хөгжимчин Хундангийн Чапаевт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 3 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 40** **Улаанбаатар хот**

**Дипломат цол олгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын дэд дарга Агваандоржийн Цолмонд Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2005 оны 3 дугаар сарын 23-ны өдөр** **Дугаар 41** **Улаанбаатар хот**

**Дипломат цол олгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Кадырын Сайраанд Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 40** **Улаанбаатар хот**

***Хүүхдийн төлөө сангийн дүрэм батлах тухай***

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийн дэргэд Хүүхдийн төлөө сан байгуулан ажиллуулсугай.

2. Хүүхдийн төлөө сангийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Ч.УЛААН**

*Засгийн газрын 2005 оны 40 дүгээр тогтоолын хавсралт*

### ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь Хүүхдийн төлөө санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийн дэргэд ажиллах Хүүхдийн төлөө сан (цаашид "Хүүхдийн төлөө сан" гэх) нь хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, санхүүгийн зохих эх үүсвэрийг үндэсний хэмжээнд бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3. Хүүхдийн төлөө зөвлөлийн дэргэд орон нутгийн Хүүхдийн төлөө сан ажиллуулж болно.

4. Хүүхдийн төлөө сан нь үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийг хамгаалах болон төсвийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

5. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулах бөгөөд түүний гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцааг төсвийн хууль тогтоомжоор зохицуулна.

6. Хүүхдийн төлөө сан нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгө бүрдүүлэх ба зарцуулах

7. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1. төсөвт тусган хуваарилсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.2. иргэн, хуулийн этгээдээс хүүхдэд зориулан өгсөн хандив, тусламж болон гэрээслэсэн хөрөнгө;

7.3. олон улсын болон гадаадын байгууллагуудаас хүүхдийн төлөө үйл ажиллагаанд зориулж хандивласан хөрөнгө;

7.4. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

8. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

8.1. хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8.2. хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах онцгой тохиолдолд тусламж үзүүлэх;

8.3. өсвөр үеийнхний оролцооны болон хүүхэд гишүүнчлэлтэй өөрийн удирдлагын байгууллагын тодорхой арга хэмжээг дэмжих.

Гурав. Хүүхдийн төлөө сангийн зохион байгуулалт, удирдлага

9. Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөл 9-11 гишүүнтэй байна.

10. Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөлийг Монгол Улсын Шадар сайд тэргүүлэх бөгөөд удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх захирлыг Хүүхдийн төлөө үндэсний Зөвлөл батална.

11. Сангийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

12. Сангийн зөвлөл асуудлыг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Сангийн зөвлөлийн тогтоолд дарга, сангийн гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.

13. Сангийн зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, дарга, сангийн гүйцэтгэх захирал нар гарын үсэг зурна.

14. Сангийн удирдах зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхтэй байна:

14.1. Хүүхдийн төлөө сангийн төсөв, санхүүгийн төлөвлөгөөг батлах, хяналт тавих;

14.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн хөрөнгийг өсгөх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжиж, хөдөлгөөн өрнүүлэх;

14.3. Сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах;

14.4. Хүүхдийн төлөө сангийн гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үр дүнг сонсох, сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;

14.5. Орон нутгийн хүүхдийн төлөө санг арга зүйн удирдлагаар хангах;

14.6. Сангийн тайлан, мэдээг хэлэлцэж Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, холбогдох бусад байгууллагад тайлагнах.

15. Хүүхдийн төлөө сангийн гүйцэтгэх захирал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1. Хүүхдийн төлөө сангийн төсөв, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөлөөр батлуулж, гүйцэтгэлийн явц, үр дүнг Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөл болон Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийн хуралд танилцуулах;

15.2. Сангийн хөрөнгийг батлагдсан төсөв, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах ажлыг зохион байгуулж, дотоод хяналт тавих;

15.3. Сангийн тайлан тэнцлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж, Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөлд улирал бүр, Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлд жилд 2-оос доошгүй удаа танилцуулан, хандивлагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд болон олон нийтэд заавал мэдээлэх;

15.4. Санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг тооцож Хүүхдийн төлөө сангийн удирдах зөвлөлд тайлагнах;

15.5. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгө өсгөх арга хэмжээг зохион байгуулах ажлыг төлөвлөх, тодорхой зорилго бүхий хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал боловсруулж Сангийн удирдах зөвлөлд танилцуулж ажиллах.

Дөрөв. Бусад зүйл

16. Хүүхдийн төлөө сан хөрөнгө өсгөх ажлыг зохион байгуулах болон түүний зорилго ба үр дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд заавал мэдээлнэ.

17. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зээлээр ашиглуулах буюу энэ дүрэмд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

18. Энэ дүрмийн 8-д заасан заалтыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

19. Хүүхдийн төлөө санг татан буулгасан тохиолдолд тус сангийн өмч, хөрөнгөтэй холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 41 | Улаанбаатар хот

***Тогтоолд өөрчлөлт оруулах тухай***

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 236 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн "... төвийг байгуулж, уг төвийн" гэснийг "төв болон Эмгэг судлалын төвийг байгуулж, тэдгээрийн" гэж өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.ГАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 42 | Улаанбаатар хот

***Нэрэмжит болгох тухай***

Холбогдох байгууллага, хамт олны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Цогт-Очирын Пэлжээгийн нэрэмжит, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг Монгол Улсын хүний гавьяат эмч Вандан-Ишийн Ичинхорлоогийн нэрэмжит болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД П.ЦАГААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот

***Үндэсний хөтөлбөр батлах тухай***

"Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай" Ерөнхийлөгчийн 2002 оны 17 дугаар зарлиг, "Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай" Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлагсугай.

2. "Морин хуур, уртын дуу" Үндэсний хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, шаардагдах зардлыг хөтөлбөрт туссан эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн дарга П.Цагаанд даалгасугай.

3. "Морин хуур, уртын дуу" Үндэсний хөтөлбөрийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД П.ЦАГААН**

***Засгийн газрын 2005 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт***

### "МОРИН ХУУР, УРТЫН ДУУ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр зэрэг төрийн бодлогын баримт бичигт ардын урлагийг төрийн ивээлд байлган судалж, сурталчлах, хадгалж, хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх талаар заасан.

ЮНЕСКО-гоос 2003 онд Монголын морин хуур хөгжмийг дэлхийн утга соёл, аман өвийн шилдэг дээжист бүртгэн тунхаглаж, батламж

олгосон нь манай соёлын түүхэнд чухал үйл явдал боллоо.

"Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 17 дугаар зарлиг, "Уртын дуугаа өвлөн дээдлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлигт морин хуур, уртын дууг сурч эзэмших, судлан шинжлэх, сурталчлан дэлгэрүүлэх цогц асуудлыг тусгасан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон юм.

Хоёр. Хөтөлбөрийн үндэслэл

Төрөөс баримтлах соёлын бодлогын утга соёлын өвийг хамгаалан хөгжүүлэх, ардын уламжлалт урлагийг төрийн ивээлд байлгах тухай зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 68 дугаар тогтоолоор "Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг батлан гаргаж, хэрэгжүүлж дуусах шатандаа орж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ардын урлагийн их наадам, уртын дуучдын, морин хуурчдын, хөөмийчдийн, ерөөлч, магтаалчдын, боржигин дуу дуулаачдын, уран нугараачдын уралдаан, буриад үндэстний "Алтаргана" наадам, урчуудын үзэсгэлэн, онол-практикийн бага хурал, симпозиум, сургалт зэрэг соёл, урлагийн 30 гаруй томоохон арга хэмжээг бүс нутаг, улс, олон улсын хэмжээнд төрөлжүүлэн зохион байгуулсан нь ач хобогдолтой болж энэ талаар багагүй туршлага бий болсон юм. ЮНЕСКО-гийн хандив, тусламжаар "Монголын аман өвийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах нь" төслийг амжилттай хэрэгжүүллээ.

2006 онд хэрэгжиж дуусах "Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийн агуулга, зорилгын залгамж чанарыг хадгалан, Монгол ардын урлагийн эртний уламжлалт гол төрөл, зүйл морин хуур, уртын дууг хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Монголчууд үндэстнийхээ түүх, соёлын хосгүй нандин өв, дурсгалуудын дотроос дуу, хуурыг онцгойлон эрхэмлэсээр ирсэн. Монгол ардын уртын дуу, морин хуур хөгжим нь хүйн холбоотой, амин шүтэлцээтэй учир цаашид хамтад нь цогцолбороор хөгжүүлэх зорилгыг эрхэм болгож байна.

Монгол ардын уртын дуу, морин хуур хэмээх энэхүү гайхамшигт бүтээлийг манай ард түмэн олон зуун жилийн өмнөөс бүтээн туурвиж, өвлүүлэн уламжлуулсаар эдүгээ хүрсэн нь манай соёлын үнэт өв сан, үндэсний бахархал мөн. XX зуунд морин хуур, уртын дууг тайз, дэлгэцийн урлагтай хослуулан хөгжүүлснээр олон зуун авьяастан, мэргэжлийн уран бүтээлч төрөн гарч, үндэсний соёл, урлаг, түүний дотор хөгжим, дууны урлагийг олон улсын түвшинд сурталчлан таниулахад чухал шинэчлэл болсон билээ.

Монгол ардын уртын дуу, морин хуурыг хадгалан хамгаалж, хойч үедээ уламжлуулах, судлан сурталчлах үйлсэд үе үеийн уртын дууч, хуурч, судлаачид үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Энэхүү Морин хуур, уртын дуу Үндэсний хөтөлбөр нь "Биет бус соёлын өвийг хамгаалах тухай" олон улсын конвенцид Монгол Улс нэгдэн орох, Монгол ардын уртын дуу болон ардын уламжлалт урлагийн бусад төрөл, зүйлийг "Дэлхийн утга соёл, аман өвийн шилдэг дээжис"-т тунхаглан бүртгүүлэхэд чухал үзүүлэлт, шалгуур болох ач холбогдолтой юм.

Үүний зэрэгцээ морин хуур, уртын дууг залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, хуурдах, дуулах эрдэмд сургаж, бүх нийтээр үндэсний бахархлын зэрэглэлээр дээдлэн дэлгэрүүлж, монгол үндэстэн, монгол хүний нэрийн хуудас, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болгох өргөн олны хөдөлгөөн өрнүүлэхэд чухал нөлөө болох учиртай.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго

3.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, төрөөс баримтлах соёлын бодлого, хууль тогтоомжид монгол үндэстэн, угсаатан, ястны өв соёл, түүх, ёс заншлыг хадгалан хамгаалах, харилцан баяжуулах, уламжлан өвлүүлэх талаар тусгагдсан асуудлын хүрээнд морин хуур хөгжим, уртын дууг хадгалж хамгаалах, уламжлан хөгжүүлэх, судалж сурталчлах ажлыг зохион байгуулах

3.1.2. Монгол ардын уртын дуу, морин хуурыг залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, дуулах, хуурдах эрдэмд сургах ажлыг бүх нийтээр үндэсний бахархлын зэрэглэлээр дээдлэн дэлгэрүүлэх, тэдгээрийг монголын төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болгох өргөн олны хөдөлгөөн өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3.2. Хөтөлбөрийн зорилтууд

3.2.1. Морин хуур, уртын дууны уламжлалт урын сан, морин хуурч, уртын дуучдын билиг авьяасыг:

- хадгалж хамгаалах;
- өвлүүлэн хөгжүүлэх;

морин хуур, уртын дууны сургалт, судалгаа, сурталчилгааг эрчимжүүлэх;

морин хуурч, уртын дуучдыг тодруулан алдаршуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

4.1.1. Морин хуур хуурдах, урлах болон уртын дуу дуулах ур чадвар, уламжлалт урын санг өвлөн эзэмшсэн билиг авьяастан, морин хуурч, уртын дуучдыг судлан тогтоох.

4.1.2. Монголын нутаг нутгийн морин хуурчид, морин хуур урлаачид, уртын дуучдын жагсаалт, каталоги бий болгох.

4.1.3. Морин хуур, уртын дууны урлагийн талаар албан бус, зайны болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах.

4.1.4. Үндэсний хөгжмийн урлал, үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжийн хүрээнд морин хуурын урлал, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжих.

4.1.5. Морин хуур, уртын дууны үзлэг, уралдаан, наадам, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.

4.1.6. Морин хуур, уртын дууны урлагийн талаархи улс, аймаг, нийслэл, байгууллагын бүртгэл-мэдээлэл, аудио, видео сан бүрдүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.

4.1.7. Морин хуурч, уртын дуучдыг тодруулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, алдаршуулах.

4.2. Морин хуур, уртын дууны судалгааг дараахь чиглэлээр явуулна:

4.2.1. Морин хуур, уртын дууны үүсэл гарвалын судалгаа;

4.2.2. Монголчуудын хөгжмийн соёл, оюун сэтгэлгээнд морин хуур, уртын дууны гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ач холбогдол;

4.2.3. Уртын дууны тархалт, орон нутаг дахь нутгийн хувилбарууд, тэдгээрийн харьцуулсан судалгаа, уртын дууг дуулах, хуур хуурдах донж маяг, дэг сургууль төрөл, зүйл, уртын дууны хөгжим;

4.2.4. Морин хуурт зориулсан хөгжмийн бүтээл /аман болон зохиолын/, морин хуур урлагийн бусад төрлүүдтэй холбогдох нь;

4.2.5. Морин хуур, уртын дууны сургалт, заах арга зүйн уламжлал, шинэчлэл;

4.2.6. Монголын алдарт хуурч, уртын дуучдын түүх, шастир, урлах эрдмийн судалгаа;

4.2.7. Морин хуур, уртын дуу монголчуудын хэв заншил, бэлгэдэл, зан үйл, төр ёсны уламжлал, ардын билигийн бусад төрлүүдтэй холбогдох нь;

4.2.8. Морин хуур урлалын уламжлалт арга, технологи, бэлгэдэл;

4.2.9. Хөрш зэргэлдээ улс орны хөгжмийн соёлд морин хуурын үзүүлсэн нөлөө, харилцан хамаарал.

4.3. Морин хуур, уртын дууны сурталчилгааг өргөжүүлэх талаар:

4.3.1. Морин хуур, уртын дууны уламжлалт урын сан, хуурчид, уртын дуучдын тухай телевиз, радиогоор сурталчлах, морин хуур, уртын дууны теле хичээл явуулах;

4.3.2. Морин хуур, уртын дууны тухай танилцуулга (CD, DVD) гаргах;

4.3.3. Морин хуур, уртын дууны тухай цуврал баримтат кино бүтээх;

4.3.4. Монгол угсаатны хөгжим, аман өвийн музей байгуулах;

4.3.5. Хуурчид, уртын дуучид болон хуурын уламжлалт урын санг сурвалжлан илрүүлэх, судлан сурталчлах, өвлүүлэн хөгжүүлэх, урамшуулан алдаршуулах зорилгоор төв, орон нутагт морин хуурчид, уртын дуучид, найрын дуучдын үзлэг, уралдаан, наадам, симпозиум, уулзалт, ярилцлага, сургалт, семинарийг үе шаттай зохион байгуулах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, мэдээллээр хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам гүйцэтгэнэ.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулах үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага

/мэргэжлийн эвлэл, холбоо, төв, студи зэрэг/ гүйцэтгэнэ.

3. Орон нутагт Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг нийслэл, дүүрэг, аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиг, үүргийг Засаг дарга батлан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.

4. Нийслэл, дүүрэг, аймаг, сумын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зохион байгуулах үүргийг аймаг, нийслэлийн соёл, урлаг, боловсролын асуудал хариуцсан захиргааны байгууллага, театр, чуулга, сумдын соёлын төв эрхлэн гүйцэтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөрийг 2005-2014 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт

Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага /аймаг, нийслэл, мэргэжлийн эвлэл, холбоо, төв, студи зэрэг/-тай зөвшилцсөний үндсэн дээр жил жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

·соёл, урлагийг дэмжих тусгай зориулалт бүхий сангийн хөрөнгө;

·гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж;

·байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

1. Морин хуур, уртын дууны урлагийг өвлөсөн ардын билиг авьяастны үйл ажиллагааг дэмжих, тэдний авьяас билиг, арга барил, дэг сургуулийг хамгаалан, хөгжүүлэх ажлын шинэ тогтолцоо бүрдэнэ.

2. Морин хуур, уртын дууны мартагдаж буй өв уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн өвлөх, хөгжүүлэх үйл ажиллагааны түвшин дээшилж, хамрах хүрээ, далайц, хүртээмж нэмэгдэнэ.

3. Морин хуур, уртын дууны судалгаа, сурталчилгаа эрчимжиж, суурь болон хавсарга судалгааны тоо, чанарт ахиц гарч, олон улсын болон улс, бүс нутаг, орон нутгийн хэмжээнд явагдах үзлэг, уралдаан, наадмын менежмент боловсронгуй болно.

4. Улс, аймаг, нийслэл, холбогдох байгууллага морин хуур, уртын дууны бүртгэл-мэдээллийн сантай болж, сонирхогч, авьяастан, уран бүтээлчдийн эрэлт, хэрэгцээг хангах, тэдэнд үйлчлэх материаллаг болон оюуны орчин бий болно.

5. Морин хуур, уртын дууны урлаг сэргэж, монгол үндэстэн, монгол хүний соёлын хэрэглээ, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болох орчин бүрдэж, олон улсын түвшинд эзлэх байр суурь дээшилнэ.

Ес. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд

Нийслэл, аймгууд "Морин хуур, уртын дуу" дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн байна.

·Морин хуур, уртын дууны талаархи байгууллага, аймаг, нийслэл, улсын бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоо бүрдсэн байна.

·Ерөнхий боловсролын сургууль бүрт морин хуур, уртын дууны албан болон албан бус сургалт явуулдаг уламжлал тогтсон байна.

·Театр, чуулга, сумын соёлын төвүүд мэргэжлийн болон авьяастан-морин хуурч, уртын дуучтай болсон байна.

·Морин хуур, уртын дууны чиглэлээр бүс нутаг, улс, олон улсын уралдаан, наадмын менежмент сайжирна.

·Морин хуур, уртын дууны урлаг сэргэж, монгол үндэстэн, монгол хүний соёлын хэрэглээ, төр ёс, баяр цэнгэл, хэв заншлын журамт шинж болох өргөн олны хөдөлгөөн өрнөсөн байна.

*Засгийн газрын 2005 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

## "МОРИН ХУУР, УРТЫН ДУУ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Санхүүжилт (сая төгрөгөөр), санхүүжилтийн эх үүсвэр | Санхүүжилтийг хариуцах байгууллага | Арга хэмжээг зохион байгуулах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| | *Морин хуур, уртын дууны уламжлалт урын сан, морин хуурч, уртын дуучдын билиг авьяасыг хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх, сургалт, судалгаа, сурталчилгааг эрчимжүүлэх* | | | | |
| 1 | Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төв, орон нутгийн соёл, урлагийн удирдах ажилтнуудын сургалт, семинар зохион байгуулна | 2005 | 2.6 | Соёл, урлагийн сан | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, |
| 2 | Үндэсний хөтөлбөрийг англи хэл дээр орчуулан, яамны ВЭБ сайтад байрлуулна. Эмхтгэл болгон хэвлүүлж сурталчилна | 2005 | 0.9 | Соёл, урлагийн сан | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл, Соёл, урлагийн сан |
| 3 | Мэргэжлийн урлаг, соёлын байгууллага /театр, чуулга, соёлын ордон, төв/-үүд морин хуур, уртын дууны сургалт, дамжаа зохион байгуулна | 2005 оноос | Байгууллагын төсөв, нөөц боломж | Мэргэжлийн урлагийн байгууллагууд, соёлын ордон, төв | Мэргэжлийн урлагийн байгууллагууд, Соёлын ордон, төв |
| 4 | Ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн хичээлийн агуулгад морин хуур, уртын дууны тухай сэдвийн эзлэх хувийн жинг нэмэх, дугуйлан хичээллүүлэх, сонгон сургалт явуулна | 2005-2006 оны хичээлийн жилээс | Байгууллагын төсөв, нөөц боломж | Ерөнхий боловсролын сургуулиуд | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Ерөнхий боловсролын сургуулиуд |
| 5 | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар радио, телевизээр цуврал сурталчилгаа, /нийтлэл, нэвтрүүлэг, сургалт /радио, теле хичээл/ явуулна | 2005-2014 | Байгууллагын төсөв, нөөц боломж | Хэвлэл, мэдээллийн байгууллага | Хэвлэл, мэдээллийн байгууллага |
| 6 | Морин хуурчдын жагсаалт, каталог хэвлэн гаргаж, сурталчилна | 2005-2007, 2010-2011 | 1.6<br>1.3<br>Нийт 2.9 | Утга соёлын өвийн Үндэсний төв | Утга соёлын өвийн Үндэсний төв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Уртын дуучдын жагсаалт, каталог хэвлэн гаргаж, сурталчилна | 2005-2007, 2010-2011 | 1.6<br>1.3<br>Нийт 2.9 | Утга соёлын өвийн Үндэсний төв | Утга соёлын өвийн Үндэсний төв |
| 8 | Морин хуурын сурах бичиг /ноот, CD-тэй/ зохиож хэвлүүлнэ | 2006-2007 | 1.4<br>3.0<br>1.4<br>Нийт 5.6 | Соёл, урлагийн сан, Морин хуурын нийгэмлэг, "Экил" сан | Соёл, урлагийн их сургууль ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн |
| 9 | Уртын дууны сурах бичиг /ноот, CD-тэй/ зохиож хэвлүүлнэ | 2007-2008 | 3.0<br>1.4<br>1.4<br>Нийт 5.8 | Соёл, урлагийн сан, Уртын дууны холбоо, Соёл, урлагийн их сургууль | Соёл, урлагийн их сургууль ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн |
| 10 | Морин хуур, уртын дууны тухай /морин хуур, хуурч, хуур урлаач, уртын дуу, уртын дуучдын тухай/ цуврал баримтат кино бүтээнэ | 2006-2013 | Жилд дунджаар 9.5<br>Нийт 76.0 | "Монгол кино" нэгтгэл ("Баримтат кино" студи) | "Баримтат кино" студи, Утга соёлын өвийн Үндэсний төв |
| 11 | "Уртын дууны их шашдир" бүтээнэ (түүх-соёл-угсаатны зүй, урлаг судлалын иж бүрэн судалгааг хамарсан суурь судалгааны бүтээл) | 2007-2010 | 5.2<br>4.6<br>Нийт 9.8 | Соёл, урлагийн сан Шинжлэх ухаан, технологийн сан | Соёл, урлаг судлалын хүрээлэн, ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн |
| 12 | Морин хуур, уртын дууны бүсчилсэн судалгаа явуулж, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлнэ | 2005-2009 | 21.7<br>8.3<br>Нийт 30.0 | ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Утга соёлын өвийн Үндэсний төв, | Судалгааны баг |
| 13 | Морин хуур, уртын дууны урлагийн талаар судалгаа хийж, аймаг, нийслэл, байгууллагын бүртгэл-мэдээллийн аудио, видео сан бүрдүүлнэ | 2005-2008 | 2.6<br>5.6<br>Нийт 8.2 | Утга соёлын өвийн Үндэсний төв, Нийслэл, дүүрэг, аймаг, сум, холбогдох байгууллага | Утга соёлын өвийн Үндэсний төв, нийслэл, дүүрэг, аймаг, сум, холбогдох байгууллага |
| 14 | Морин хуур, уртын дууны урлагийг гадаад оронд сурталчлах чиглэл, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ | 2006-2010 | - | Тухайн улс, байгууллагатай хийсэн гэрээ, хэлэлцээрийн дагуу БСШУЯ, төрийн бус байгууллагууд | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам, Зам, тээвэр, аялал жуулчлалын яам |
| 15 | Морин хуурын сургагч-багш нарын бүсийн сургалт зохион байгуулна | 2005-2006 | 8.0 | ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс | Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Морин хуур сонирхогч сурагчдын бүсийн сургалт (4 бүсэд сонгосон дунд сургуульд) зохион байгуулна | 2006-2007 | 22.0 | ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс | Аймгийн Боловсрол, соёлын газар, театр, чуулга, Утга соёлын өвийн Үндэсний төв |
| 17 | Морин хуурч, уртын дуучдын Үндэсний семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна | 2005-2006 | 5.0 | ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс | БСШУЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс |
| 18 | Ерөнхий боловсролын сургууль, байгууллага, аж ахуйн нэгжийг түшиглэн "Морин хуур хөгжмийн сургууль" байгуулах асуудлыг дэмжиж, үйлчилгээ үзүүлнэ | 2006-2014 | 10.0 | Гадаад орон, олон улсын байгууллага, дотоод, гадаадын байгууллага, иргэд | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл |
| 19 | Монгол ардын уртын дууг "Хүн төрөлхтний утга соёл, аман өвийн шилдэг дээжис"-т нэр дэвшүүлнэ | 2005-2006 | 14.0 | ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс | БСШУЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс |
| 20 | Үндэсний хөгжмийн үйлдвэрлэл, морин хуурын үйлдвэрлэлийг дэмжиж, үйл ажиллагаа нь урамшуулах, үйлдвэрлэл-хэрэглээг уялдуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлнэ | 2005-2014 | - | Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж | БСШУЯ, Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж |
| 21 | Монгол Улс "Биет бус соёлын өвийг хамгаалах тухай" олон улсын конвенцид нэгдэн орох тухай асуудлыг боловсруулж, Засгийн газар, Улсын Их Хуралд уламжилна | 2005-2006 | - | - | БСШУЯ, Гадаад хэргийн яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс |
| | *Морин хуур, уртын дууны талаар зохион байгуулах арга хэмжээ, морин хуурч, хуур урлаач, уртын дуучдыг дэмжин урамшуулах* | | | | |
| 22 | Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан Ардын урлагийн их наадамд оролцуулах морин хуурч, уртын дуучдыг нийслэл, аймгаас шалгаруулах бүсийн урлагийн үзлэг зохион байгуулна | 2005-2006 | 4.2<br>4.0<br>Нийт 8.2 | Соёл, урлагийн сан, Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үндэсний хороо | Ардын урлагийн их наадам зохион байгуулах Үндэсний хороо, аймаг, нийслэлийн салбар хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойгоор 1000 морин хуурч, 1000 уртын дууч оролцуулсан Ардын урлагийн их наадам зохион байгуулна | 2006 | 96.8<br>81.2<br>30.0<br>Нийт 208.0 | Соёл, урлагийн сан,<br>Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үндэсний хороо,<br>аймаг, нийслэлийн ЗДТГ | БСШУЯ,<br>Ардын урлагийн их наадам зохион байгуулах хороо |
| 24 | Завхан аймаг дахь Хөгжим, бүжгийн коллежийн морин хуурын чуулгын тоглолтыг нийслэл хотноо хийлгэнэ | 2005 | 4.1 | Соёл, урлагийн сан | БСШУЯ, Завхан аймгийн Хөгжим, бүжгийн коллеж |
| 25 | Өвөрийн морин хуурч, уртын дуучдын наадам зохион байгуулна | 2008, 2010, 2012, 2014 | 5.6<br>5.6<br>11.6<br>Нийт 22.4 | Морин хуурын нийгэмлэг,<br>Соёл, урлагийн сан,<br>Нийслэл, аймгийн ЗДТГ | Морин хуурын нийгэмлэг, Соёл, урлагийн сан, Утга соёлын өвийн Үндэсний төв, Нийслэл, аймгийн ЗДТГ, Уртын дууны холбоо |
| 26 | Морин хуур урлаачдын улсын III, IY, V уралдаан, үзэсгэлэн, худалдаа зохион байгуулна | 2006, 2009, 2012 | 2.3<br>2.9<br>Нийт 5.2 | Соёл, урлагийн сан,<br>Морин хуурын нийгэмлэг | Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл, Морин хуурын нийгэмлэг, "Экил" сан |
| 27 | Монгол угсаатны хөгжим, аман өвийн музей байгуулан ажиллуулна | 2007-2009 | 4.1<br>11.1<br>Нийт 15.2 | Соёл, урлагийн сан,<br>Утга соёлын өвийн үндэсний төв | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Утга соёлын өвийн үндэсний төв |
| 28 | Төвийн бүсийн ардын авьяастан-уртын дуучдын үзлэг явуулна | 2009 | 1.0<br>3.2<br>Нийт 4.2 | Соёл, урлагийн сан,<br>Холбогдох аймгуудын ЗДТГ | Ардын урлагийн их наадам зохион байгуулах хороо, холбогдох аймгуудын ЗДТГ |
| 29 | Баруун бүсийн ардын авьяастан-уртын дуучдын үзлэг явуулна | 2010 | 1.0<br>3.2<br>Нийт 4.2 | Соёл, урлагийн сан,<br>Холбогдох аймгуудын ЗДТГ | Ардын урлагийн их наадам зохион байгуулах хороо, холбогдох аймгуудын ЗДТГ |
| 30 | Зүүн бүсийн ардын авьяастан-уртын дуучдын үзлэг явуулна | 2011 | 1.0<br>3.2<br>Нийт 4.2 | Соёл, урлагийн сан,<br>Холбогдох аймгуудын ЗДТГ | Арлын урлагийн их наадам зохион байгуулах хороо, холбогдох аймгуудын ЗДТГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | "Морин хуур, уртын дууны судлалын өнөөгийн байдал, цаашид хөгжүүлэх арга зам" сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурал | 2008 | 5.0<br>3.8<br>Нийт 8.8 | ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс,<br>Соёл, урлагийн сан | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёл, урлагийн хүрээлэн, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн |
| 32 | "Морин хуур, уртын дуу Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, цаашдын зорилт" эрдэм шинжилгээний хурал | 2014 | 2.2<br>2.0<br>Нийт 4.2 | Соёл, урлагийн сан,<br>Утга соёлын өвийн Үндэсний төв, | Ардын урлагийн их наадам зохион байгуулах хороо, |
| 33 | Ардын хувьсгалын 90 жилийн ойд зориулсан Олон улсын ардын урлагийн их наадамд оролцуулах морин хуурч, уртын дуучдыг нийслэл, аймгаас шалгаруулах бүсийн урлагийн үзлэг зохион байгуулна | 2010-2011 | 9.1 | Соёл, урлагийн сан | Ой тэмдэглэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороо,<br>Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| 34 | Морин хуурч, уртын дуучдын Олон улсын их наадам (хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг олон түмэнд тайлагнах соёлын цогцолбор арга хэмжээ) зохион байгуулна | 2014 | 13.0<br>10.0<br>10.7<br>Нийт 33.7 | Соёл, урлагийн сан,<br>Утга соёлын өвийн Үндэсний төв,<br>ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс | Зохион байгуулах Үндэсний хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| 35 | "Морин хуур, уртын дуу" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд амжилт гаргасан байгууллагыг 2 жил тутам шалгаруулан шагнана | 2007-2014 | 5.0<br>5.0<br>Нийт 10.0 | Соёл, урлагийн сан,<br>ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл |
| 36 | Морин хуур, уртын дууны ховор, хосгүй өвийг уламжилсан ардын авьяастныг тодруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын батламж, нэрэмжит шагнал олгож байна | 2006 оноос | Жил тутам 3.0<br>нийт 27.0 | Соёл, урлагийн сан | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Утга соёлын өвийн Үндэсний төв, Морин хуурын нийгэмлэг, Уртын дууны холбоо |
| 37 | Морин хуур, уртын дууны урлагийг судлах, сургах, сурталчлан дэлгэрүүлэхэд амжилт гаргасан ардын авьяастан, уран бүтээлч, судлаач, соёл, нийгмийн зүтгэлтэнг Монгол улсын төр, Засгийн газрын болон бусад байгууллагын шагналаар шагнуулах арга хэмжээ авна | 2005-2014 | Тухайн байгууллагын дүрэм, журмаар | Төрийн болон төрийн бус байгууллагууд | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл |
| 38 | Олон улсын урлагийн наадам, уралдаан, тэмцээнд морин хуурч, уртын дуучдыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам боловсруулж, хэрэгжүүлнэ | 2007 оноос | Батлагдсан журмаар шийдвэрлэнэ | | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |

*Засгийн газрын 2005 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт*

**"МОРИН ХУУР, УРТЫН ДУУ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

| | |
|---|---|
| Дарга | -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| Гишүүд: | -ЮНЕСКО-гийн Монголын үндэсний Комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга;<br>-Боловсрол,соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын дарга;<br>-Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;<br>-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга;<br>-Боловсрол,соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын хэлтсийн дарга;<br>-Соёл,урлагийн их сургуулийн захирал;<br>-Үндэсний дуу,бүжгийн эрдмийн чуулгын дарга;<br>-Утга соёлын өвийн Үндэсний төвийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;<br>-Морин хуурын төвийн ерөнхийлөгч /тохиролцсоноор/;<br>-Уртын дууны холбооны тэргүүн /тохиролцсоноор/. |
| Нарийн бичгийн дарга | -Боловсрол,соёл, шинжлэх ухааны яамны утга соёлын өвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн. |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 46** **Улаанбаатар хот**

*Усны хэрэг эрхлэх газар байгуулах тухай*

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Усны хэрэг эрхлэх газар байгуулсугай.

2. Усны хэрэг эрхлэх газрын харьяанд аж ахуйн тооцоон дээр ажиллаж, зардлаа орлогоороо нөхөх Усны хэмнэлтийн төв байгуулахыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтын "Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсний "15.Байгаль, ой, усны нөөцийн газар" гэсэн заалтыг "Усны хэрэг эрхлэх газар" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 48** **Улаанбаатар хот**

*Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 162 дугаар тогтоолын хавсралтад

| | | |
|---|---|---|
| Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 9. Онцгой байдлын ерөнхий газар | |

гэж нэмсүгэй.

2. "Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоол, түүний хавсралтад дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а/тогтоолын 1, 2 дугаар зүйлийн "Гамшгаас хамгаалах ерөнхий газрын" гэснийг "Онцгой байдлын ерөнхий газрын" гэж;

б/тогтоолын 3 дугаар зүйлийн "аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штабыг" гэснийг "нийслэлийн Онцгой байдлын газар, аймаг, дүүргийн Онцгой байдлын хэлтсийг" гэж;

в/тогтоолын 6 дугаар зүйлийн "Гамшгаас хамгаалах штабт" гэснийг "Онцгой байдлын газар (хэлтэс)-т" гэж;

г/мөн тогтоолын хавсралтын 1-21 дэх заалтын "аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб" гэснийг "аймгийн Онцгой байдлын хэлтэс", 22 дахь заалтын "Нийслэл дэх Гамшгаас хамгаалах штаб", "... дүүргийн Гамшгаас хамгаалах штабууд" гэснийг "Нийслэлийн Онцгой байдлын газар", "дүүргийн Онцгой байдлын хэлтсүүд", 23 дахь заалтын "Гамшгаас хамгаалах тусгай анги (шуурхай бүлэгтэй)" гэснийг "Аврах тусгай анги (тээврийн хэсэгтэй)" гэж.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 162 дугаар тогтоолын хавсралтын "3². Гамшгаас хамгаалах ерөнхий газар", "Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолын хавсралтын 24 дэх заалтын "(тээврийн хэсэгтэй)" гэснийг тус тус хасч, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД У.ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 49 — Улаанбаатар хот**

***Элчин сайдын яаманд газар нэмж ашиглуулах тухай***

Газрын тухай хуулийн 18.1.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот дахь Бүгд Найрамдах Болгар Улсын Элчин сайдын яаманд ашиглуулж байгаа газрын хэмжээг харилцан адил байх зарчмыг үндэслэн 9180 кв.м-ээр тогтоосугай.

2. Бүгд Найрамдах Болгар Улсын Элчин сайдын яамны одоо ашиглаж байгаа 12529 кв.м газраас 5039 кв.м газрыг буцаан авч, зэргэлдээх 1690 кв.м газрыг нэмж олгон заагийг нь тогтоож, гэрээ байгуулан ажиллахыг Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 50 — Улаанбаатар хот**

***Элчин сайдын яаманд газар нэмж ашиглуулах тухай***

Газрын тухай хуулийн 18.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 55 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот дахь Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яаманд 1800 кв.м газрыг нэмж ашиглуулахаар тогтоосугай.

2. Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яаманд нэмж ашиглуулахаар олгосон газрын заагийг тогтоон гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Ц.МӨНХ-ОРГИЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 6. Мэнгийн хөгжлийн зорилтуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах механизм байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мянганы Хөгжлийн Зорилтуудын үндэсний хэрэгжилтийн тухай илтгэл, мэдээллийг НҮБ-д гаргаж өгч байна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 7. Улс орны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ, түүний системийн байгууллагуудтай хамтын ажиллагааны хөтөлбөр байгуулж ажиллана. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| 331 | 7.1.10 | Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын V бага хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой үйл ажиллагаа явуулж, тус хөдөлгөөнд оролцогч орнуудтай идэвхтэй хамтран ажиллана. | 1. V бага хурлаас баталсан Улаанбаатарын Тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрийг олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр НҮБХХ-тэй хамтран батлсан "Ардчилал Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын олон улсын V бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх нь" төслийг хэрэгжүүлнэ. | 2004-2006 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. Ардчиллын хамтын нөхөрлөлийн орнуудын хөдөлгөөнтэй Ардчилал Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын хөдөлгөөнийг ойртуулах талаар Чилийн тал болон зохион байгуулах бүлгийн бусад улс орнуудтай харилцан ажиллана. | 2004-2006 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 3. Катар Улсын Доха хотноо болох Ардчилал Шинээр Сэргээн Тогтоосон Орнуудын VI бага хуралд V бага хурлыг даргалагч Монгол Улсын илтгэлийг боловсруулж өргөн барина. | 2006 | Ц.Мөнх-Оргил |
| 332 | 7.1.11 | Уламжлалт харилцаатай орнуудтай шинэ нөхцөлд зохицуулан сэргээн хөгжүүлж буй харилцаанд гарсан ахицыг бататгаж, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлээр ажиллана. | 1. Уламжлалт харилцаатай орнуудтай улс төрийн яриа хэлэлцээг үргэлжлүүлж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, үүний дотор худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, давхар татвар ногдуулахаас зайлсхийх, хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах болон бусад хэлэлцээрүүдийг байгуулах чиглэлээр ажиллана. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил<br>С.Батболд<br>Н.Алтанхуяг |
| | | | 2. Өндөр, дээд хэмжээний айлчлалуудыг тогтмолжуулах чиглэл барьж ажиллана. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил |
| 333 | 7.1.12 | Гадаадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг боловсронгуй болгох, Консулын албыг бэхжүүлэх арга хэмжээг авна. | 1. Монгол иргэд гадаадад зорчих, хөдөлмөр эрхлэх, сурах, оршин суух таатай нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгох ажлыг үргэлжлүүлнэ. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил<br>Ц.Баярсайхан |
| | | | 2. Иргэд гадаадад зорчиход шаардагдах мэдээлэл, гадаад оронд хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахад чиглэсэн ажлыг зохион байгуулж, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр өргөн сурталчилна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил<br>Ц.Баярсайхан |
| | | | 3. Монголын иргэд гадаад оронд тачигдал зовлон тохиолдоход тусламж, дэмжлэг үзүүлэх сан байгуулах боломжийг судална. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил<br>Н.Алтанхуяг |
| | | | 4. Орчин үеийн мэдээллийн технологи, техникийг консулын үйл ажиллагаанд өргөн нэвтрүүлэн ашиглана. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 5. Консулын албаны эрх зүйг төгөлдөржүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |

*Төгсгөл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны №10, 11, 12-д нийтлэгдсэн.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 6. Гадаад орнуудын Гадаад хэргийн яамны Консулын албадтай хийх Консулын зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 7. Өргөмжит консулын албыг өргөтгөх, эрх зүйн орчныг нь төгөлдөржүүлэх чиглэлээр ажиллана. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 8. Зарим консулын албадын иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаатай танилцаж, заавар, зөвлөгөөр өгөх, гадаадад амьдарч байгаа иргэдийн эрх ашигийг хөндсөн иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг судлан шийдвэрлүүлнэ. | 2005- 2006 | Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил |
| 334 | 7.1.13 | Дипломат албыг төрийн мэргэшсэн тусгай албын хувьд эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгааллын чиглэлээр бэхжүүлж, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр хуулийн хүрээнд сэлбэх журмыг тууштай хэрэгжүүлнэ. | 1. Боловсон хүчний бодлого, давтан сургалтын хөтөлбөрт шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг тусгаж батлуулан мөрдөнө. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. Дипломат албаны тухай хууль, системийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа журам, зааврын хэрэгжилтийг сайжруулах тодорхой ажил зохионо. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 3. Боловсон хүчний нэгдсэн болон төрөлжсөн судалгааг үндэслэл сайтай боловсруулна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 4. Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн мэргэшсэн тусгай албаны статус, албан хаагчдын эрх ашиг, нийгмийн баталгааг хуульчлан хангах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | 2005 | Ц.Мөнх-Оргил |
| 335 | 7.1.14 | Монгол Улсын дипломат төлөөлөгчдийн газруудын байршлыг илүү оновчтой, үр ашигтай болгох, дипломатуудын ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах талаар санал боловсруулж, шат дараатай хэрэгжүүлнэ. | 1. Дипломат төлөөлөгчдийн газруудын байршил, бүтэц, орон тоо, чиг үүрэг, улс төрийн болон бусад ашиг сонирхлын ач холбогдлыг тооцсон судалгаа гарган, санал боловсруулж танилцуулна. | 2004-2005 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. Дипломат төлөөлөгчдийн газруудыг Итали, Австрали, Скандинавын аль нэг оронд шинээр нээх боломжийг судална. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 3. Дипломат төлөөлөгчдийн газруудыг мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах ажлыг холбогдох бусад байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 4. Сингапур Улс дахь Ерөнхий Консулын Газрыг Элчин Сайдын Яам болгон статусыг нь дээшлүүлнэ. | 2005 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 5. Дипломат төлөөлөгчдийн газруудын тэргүүн, нэгжийн ажлын үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгох арга хэмжээ авна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| 336 | 7.1.15 | Монголын түүх, соёл, өнөөгийн байдлыг гадаад ертөнцөд сурталчлах, Монголын тухай зөрөг ойлголтыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна. | 1. Гадаад сурталчилгааны арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөх, зохицуулах механизм бий болгоно. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 2. Гадаад сурталчилгааны үндсэн чиглэлийг боловсруулна. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Монголын тухай зөрөг ойлголтыг бэхжүүлэх цогцолбор арга хэмжээний мастер төлөвлөгөө тодорхой улс оронд тохируулан боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 4. Монголын талаарх олон нийтийн ойлголтын тухай судалгааг зарим оронд хийнэ. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил |
| **Найм. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ** | | | | | |
| **8.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийн амгалан тайван аюулгүй байдлыг хангах талаар орон нутгийн эрх мэдлийг өргөжүүлж, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 337 | 8.1.1 | Нийгмийн бүх шатанд авилгалтай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, албан тушаалын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд чиглэсэн үр дүнтэй систем бүрдүүлнэ. | 1. Эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах албаны авилгал, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үүрэгтэй нэгжийн бүтцийг өөрчлөн зохион байгуулж прокурор, шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдыг мэргэшүүлэх сургалтад үе шаттай хамруулна. | 2005–2007 | Ц.Нямдорж |
| | | | 2. Авилгал, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх үүрэг бүхий албадыг орчин үеийн техник, шаардлагатай хүч хэрэгслээр үе шаттайгаар хангана. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 3. Авилгалын эсрэг хуулийг шинэчлэн боловсруулна. | 2005- 2006 | Ц.Нямдорж |
| | | | 4. Авилгал, албан тушаалын болон зохион байгуулалттай бусад гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар судалгаа хийж, эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар санал зөвлөмж гаргана. | 2005–2007 | Ц.Нямдорж |
| 338 | 8.1.2 | НҮБ-ын авилгалын эсрэг конвенцид нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 1. Уг конвенцид нэгдэх асуудлыг судалж, шийдвэрлэнэ. | 2005-2008 | Ц.Мөнх-Оргил Ц.Нямдорж |
| 339 | 8.1.3 | Албан тушаалтнуудын орлогын мэдүүлгийг нээлттэй болгоно. | 1. Төрийн албан хаагчийн орлогын мэдүүлгийг нээлттэй болгох чиглэлээр Авилгалын эсрэг хуульд тусгах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ. | 2005- 2006 | Ц.Нямдорж |
| 340 | 8.1.4 | Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэн энэ асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна. | 1. Нутгийн захиргаа, төрийн бус байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлөөс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажлын явц, үр дүнд төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгнө. | 2005 оноос эхлэн 2 жилд 1 удаа | С.Баярцогт Ц.Нямдорж |
| | | | 2. Энэ чиглэлээр ажиллаж буй бүх байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, семинар, ярилцлагыг жил тутам зохион байгуулж байна. | 2005 оноос жил бүр | Ц.Нямдорж |
| | | | 3. Иргэдийг олон нийтийн байцаагч, урамшилтай эргүүл, жижүүрээр ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авна. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, санал боловсруулна. | 2005 | Ц.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна. | 2006 | Ц.Нямдорж |
| | | | 6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад оруулан төлөвлөж, Зохицуулах зөвлөлөөс төв, орон нутагт хуваарилан санхүүжүүлдэг журамд шилжих асуудлыг судална. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг |
| | | | 7. Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд туслах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа Албан бус сургалтын төв, Хүний эрхийн боловсролын төв болон бусад Төрийн Бус Байгууллагын үйл ажиллагаа уялдуулж дэмжлэг үзүүлнэ. | 2005–2007 | Ц.Нямдорж |
| 341 | 8.1.5 | Цагдаагийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулна. | 1. Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг удирдах ажлын арга зүйн зөвлөмж гаргаж хэрэгжүүлнэ. | 2005 | Ц.Нямдорж |
| | | | 2. Тухайн нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажлын явц, үр дүнг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа хэлэлцэн, тодорхой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх үйл ажиллагаар хэвшүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 342 | 8.1.6 | Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр оногдуулж байгаа журмыг өөрчилж, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх асуудлыг судалж, шийдвэрлэнэ. | 1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр оногдуулж, тооцож байгаа практикийг судалж, бусад орны цагдаагийн байгууллагын арга хэлбэрийг харьцуулан судалж, дүгнэлт гаргана. | 2005 | Ц.Нямдорж |
| | | | 2. Аймгийн төв, нийслэлийн цагдаагийн эрх бүхий албан тушаалтнаас ногдуулсан торгуулийн төлбөр тооцоог бэлэн бусаар хийх асуудлыг судалж шийдвэрлэнэ. | 2006–2008 | Ц.Нямдорж |
| 343 | 8.1.7 | Хууль хяналтын байгууллагад ажиллагсдын цалин, хангамжийг нэмэгдүүлж, тэдэнд тавих хуулийн шаардлагыг чангатгана. | 1. Хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг сайжруулах талаар эрх зүйн орчин бий болгоно. | 2005 | Ц.Нямдорж<br>И.Эрдэнэбаатар |
| | | | 2. Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчдын ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авна. | 2005-2008 | И.Эрдэнэбаатар |
| 344 | 8.1.8 | Улс, үндэстэн дамнасан зэрэг шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зохион байгуулалт, бэлэн байдлыг сайжруулж, үр дүнг дээшлүүлнэ. | 1. ОХУ-ын хил залгаа бүс нутгийн дотоод хэргийн байгууллагуудтай хил дамнан үйлдэгдэж буй гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл солилцон, харилцан хамтын ажиллагааг эрчимжүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2006–2008 | Ц.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 345 | 8.1.9 | Замын хөдөлгөөнд хяналт тавих телекамерийн хяналтын системийг бий болгож, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 1. Нийслэл хотод замын теле хяналтын систем бий болгох чиглэлээр төсөл боловсруулж, хэрэгжих эх үүсвэрийг шийдэж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.<br>2. Замын хөдөлгөөний хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд иргэдээс тавих хяналтыг сайжруулна.<br>3. Замын хөдөлгөөнийг цагдаагийн оролцоотой зохицуулах эрхийг олон нийтийн байцаагч, урамшилтай эргүүлд олгох асуудлаар холбогдох хууль, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, тэдний урамшууллын эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах талаар санал боловсруулна.<br>4. Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдыг автомашин сонирхогчийн сургалтад хамруулах замаар хөдөлгөөний аюулгүй байдалд сургаж дадлагажуулна. | 2005–2008<br>2005–2008<br>2005–2008<br>2006-2008 | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг<br>Нийслэлийн Засаг дарга<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>П.Цагаан<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 346 | 8.1.10 | Бие хүний өгөгдөл, гарын хурууны хээ, нүдний цэцгийн тусгалын мэдээллийн улсын нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж санал боловсруулна. | 1. Монгол Улсын иргэдийн гар, хурууны хээний нэгдсэн санг тэдний сайн дурын үндсэн дээр бий болгох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судалж санал боловсруулна.<br>2. Аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллагад гар, хурууны хээний "Папилон" систем нэвтрүүлэх асуудлаар төсөл боловсруулж шийдвэрлэнэ. | 2005<br>2006 | Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг |
| 347 | 8.1.11 | Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч, автомашины парк шинэчлэлт, холбоо, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох, зэвсэг, тусгай хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх, криминалистикийн шинжилгээний техник, тоног төхөөрөмжөөр хангах төслүүдийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 1. Цагдаагийн автомашины парк шинэчлэлтийн төслийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.<br>2. Хуулийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох асуудлыг боловсруулж шийдвэрлэнэ.<br>3. Сумдын цагдаагийн хэсгийн төлөөлөгчийг аймгийн төвтэй радио холбооны сүлжээгээр холбох асуудлыг боловсруулж шийдвэрлэнэ.<br>4. Цагдаагийн байгууллагыг зэвсэг, тусгай хэрэгслээр хангах төслийг боловсруулж шийдвэрлүүлнэ.<br>5. Аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэст Криминалистикийн бичил лаборатори бий болгох төслийг боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2005–2008<br>2005–2008<br>2005–2008<br>2006–2008<br>2006–2008 | Ц.Нямдорж,<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж |
| 348 | 8.1.12 | Иргэдэд цагдаагийн ажил, үйлчилгээг ойртуулах зорилгоор байнгын пост (кобон систем)-ыг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 1. Сумдын хэсгийн төлөөлөгчийн ажиллаж, амьдрах "Кобон" байгуулах асуудлаар төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 349 | 8.1.13 | Иргэний бүртгэл, мэдээлэл, шилжих хөдөлгөөн, гадаадын иргэн, харьяатын асуудал, иргэний бүртгэл, мэдээллийн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Дотоод, гадаадын иргэдийн хилээр орох, гарах бүртгэлийг сайжруулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулна. | 2005–2006 | Ц.Нямдорж |
| | | | 2. Аймаг, нийслэл, сумыг хамарсан иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийн санг найдвартай ажиллуулахад шаардлагатай орчин үеийн техник, хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авна. | 2005–2006 | Ц.Нямдорж |
| | | | 3. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын байцаагчдыг сумдад ажиллуулах замаар иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын үр нөлөө, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх арга хэмжээ авна. | 2005 | Ц.Нямдорж |
| | | | 4. "Монгол Улсын иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ыг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлнэ. | 2006–2008 | Ц.Нямдорж |
| | | | 5. Иргэний баримтын төв архивын санд байгаа иргэний бүртгэлийн баримтуудыг нэгтгэж, иргэн бүрийг хувийн хэрэгтэй болгоно. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 6. Иргэний баримтын төв архивын 1951 оноос 1989 он хүртэлх иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн анкет, маягтыг мэдээллийн цахим санд оруулна. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 7. Иргэний баримтын төв архив, түүний үндсэн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2005 | Ц.Нямдорж |
| | | | 8. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албыг олон улсын жишигт тохирсон бүтэц, зохион байгуулалттай болгон бэхжүүлж, өөрийн байртай болгох асуудлыг шийдвэрлүүлнэ. | 2005-2006 | Ц.Нямдорж |
| 350 | 8.1.14 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоог боловсронгуй болгон шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 1. Шийдвэр гүйцэтгэх байгууллагад шинээр ажилд орох, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй хүмүүс, ажилдаа алдаа, зөрчил гаргасан ажилтнуудыг тус бүр сургалтын тусгай төлөвлөгөөтэйгээр сургалтад хамруулна. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Ажилтнуудын ажиллах, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулан, тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 3. Нийслэлийн Дарь-Эх дэх ялын дэглэм буурсан ялтнуудын ялыг эдлүүлэх тусгай салбарыг төвлөрсөн хорих анги болгон өргөтгөн, өөрчлөн зохион байгуулах асуудлыг шийдвэрлүүлнэ. | 2007 | Ц.Нямдорж |
| | | | 4. Эрүү, иргэний хэргийн эд хөрөнгө, төлбөр гаргуулах, торгох болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэхтэй холбогдсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тоо бүртгэл, мэдээлэл, судалгааг компьютерийн нэгдсэн сүлжээнд оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2005–2006 | Ц.Нямдорж |
| | | | 5. Олон улсын жишигт нийцсэн нөхцөл, шаардлагыг хангасан нэгдсэн ангийг шинээр барих хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад тавин шийдвэрлүүлнэ. | 2007 | Ц.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 351 | 8.1.15 | Олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгийн судалгаа хийж, олон улсын гэрээний нэгдсэн сан байгуулахын зэрэгцээ хууль тогтоомжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх ажлыг судалж шийдвэрлэнэ. | 1. Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээний цахим санг бүрдүүлэх арга хэмжээ авч, мэдээллийн сүлжээнд холбоно.<br>2. Монгол Улсын хууль тогтоомжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх асуудлаар судалгааны ажил гүйцэтгэж, холбогдох арга хэмжээг авна.<br>3. Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээний монгол хэлээрх албан ёсны орчуулгыг хийж, Төрийн мэдээлэл эмхтгэлд нийтэлнэ. | 2005–2006<br>2005–2007<br>2005-2007 | Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил |
| 352 | 8.1.16 | Үндсэний хууль тогтоомжийн системчлэлийг боловсронгуй болгож, эрх зүйн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ. | 1. Эрх зүйн нэгдсэн ангиллыг нэг мөр хэрэглэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үндэсний хууль тогтоомжийг нэгдсэн ангиллаар системчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.<br>2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулна.<br>3. Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудыг бэлтгэн сугалбар хуудастайгаар 6 ботиор бэлтгэн гаргана.<br>4. Иргэдэд хуулийг тайлбарлан таниулж сурталчлах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрх зүйн сэдэвтэй CD, ном, гарын авлага, зурагт хуудсыг төлөвлөгөөний дагуу гаргаж, нийтийн хүртээл болгоно.<br>5. Монгол Улсын түүхэнд холбогдох /1206-2006/ он дараалсан хуулийн эмхтгэлийг бэлтгэн 16 ботиор хэвлэн гаргана. | 2005–2008<br>2005–2008<br>2005–2006<br>2005–2007<br>2005–2007 | Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж |
| 353 | 8.1.17 | Гэмт хэрэг, гэм буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх зохистой механизмыг судалж, эрх зүйн үндсийг нь бүрдүүлнэ. | 1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тогтолцоо, хөрөнгийн эх үүсвэрийн талаар судалж, санал боловсруулан эрх бүхий байгууллагад оруулна. | 2005–2006 | Ц.Нямдорж |
| 354 | 8.1.18 | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн ажлыг зохион байгуулна. | 1. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний үндсэн дээр гүйцэтгэнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 355 | 8.1.19 | Төсөв, гадаадын зээл тусламж, татвар, нийгмийн даатгалын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад олон нийтийн зүгээс хяналт тавих, энэ чиглэлээр бий болсон өр төлбөрийг барагдуулж байх зохистой механизм бүрдүүлнэ. | 1. Төсөв, гадаадын зээл тусламж, татвар, нийгмийн даатгалын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих энэ чиглэлээр бий болсон өр төлбөрийг барагдуулж байх зохистой механизм бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.<br>2. Уг судалгаанд үндэслэн төсөв, гадаадын зээл тусламж, татвар, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгох чиглэлээр холбогдох арга хэмжээг авна. | 2006<br>2007 | Н.Алтанхуяг<br>Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг<br>Ц.Баярсайхан |
| 356 | 8.1.20 | Төрийн албан хэрэг хөтлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, архивын салбарт тоон мэдээллийн системийг нэвтрүүлэн архивын байрны хадгалалт, хамгаалалт, дохиоллын системийг үе шаттайгаар сайжруулна. | 1. Төрийн албан хэрэг хөтлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.<br>2. Архивын байрны хадгалалт, хамгаалалт, дохиоллын системийг үе шаттайгаар сайжруулна. | 2005–2007<br>2005–2008 | Ц.Нямдорж<br>Ц.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3. Цагдаагийн байгууллагын төрөлжсөн архивыг бий болгож, зориулалтын байрны асуудлыг шийднэ. | 2005-2008 | Ц.Нямдорж |
| | | | 5. Төрийн байгууллагуудын архивын баримтын эрэлт-хайлтыг боловсронгуй болгох үүднээс баримтыг тоон системд шилжүүлж эхэлнэ, нэгдсэн сан үүсгэнэ. | 2005-2007 | Ц.Нямдорж |
| | | | 6. Төрийн архивуудыг галын болон аюулгүйн дохиоллын хамгаалалттай болгох зорилтыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ. | 2005-2006 | Ц.Нямдорж |
| | | | 7. Байнга хадгалах баримт бичгийг хадгалалтын олон улсын стандартын шаардлагыг хангасан цаасан дээр үйлдэх, буулгах ажлыг зохион байгуулж хэвшүүлнэ. | 2005-2007 | Ц.Нямдорж |
| | | | 8. Төрийн архивуудад тохиож болох гэнэтийн осол, гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ. | 2005-2007 | Ц.Нямдорж |
| | | | 9. Гадаад хэргийн архивын ажлын арга зүй, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь сайжруулах, тэргүүн туршлага, ололт амжилтыг архивын ажилд нэвтрүүлнэ. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 10. Гадаад хэргийн архивыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах ажлыг өөрийн хүч хөрөнгө болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил |
| | | | 11. Гадаад хэргийн архивын үйл ажиллагаар автоматжуулах, баримтыг тоон хэлбэрт оруулахад шаардлагатай программ хангамжийг бий болгон эрэлт хайлтын автоматжуулсан сан байгуулна. | 2004-2008 | Ц.Мөнх-Оргил |
| 357 | 8.1.21 | Хуульчдын боловсрол, мэдлэг чадвар, ёс зүйд тавих шаардлагыг өндөржүүлж, тэдгээрийн давтан сургалт, сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгоно. | 1. Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2005-2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчийг зах зээл хөгжсөн өндөр хөгжилтэй орнуудад төрийн зардлаар урт, богино хугацааны сургалтад хамруулна. | 2006-2008 | Ц.Нямдорж |
| | | | 3. Хуульчдын сонгон шалгаруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна. | 2005-2006 | Ц.Нямдорж |
| | | | 4. Хуульчдын болон төрийн зарим албан хаагчийн мэдлэг чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх үргэлжилсэн, давтан сургалтыг зохион байгуулна. | 2005–2007 | Ц.Нямдорж |
| | | | 5. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэшсэн хуульч /цагдаа, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч г.м/ бэлтгэх, давтан сургах арга хэмжээ авна. | 2005-2007 | Ц.Нямдорж<br>Ч.Улаан<br>Ц.Баярсайхан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 358 | 8.1.22 | Мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх асуудалд эрс өөрчлөлт гаргана. | 1. Мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх үүрэгтэй сумын хэсгийн төлөөлөгчийг унаалга, бусад шаардлагатай техник, хэрэгслээр хангах арга хэмжээ авна. | 2006-2008 | Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 2. Бусдын өмчийг хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тавих иргэний хяналтыг өндөржүүлнэ. | 2006–2008 | Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 3. Архаг архичдыг эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг судлан боловсруулж холбогдох байгууллагад оруулна. | 2006-2008 | Ц.Нямдорж<br>Т.Ганди |
| | | | 4. Архидан согтуурах явдалтай хийх тэмцэлд иргэд, гэр бүл, албан газар, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ. | 2005- 2008 | Ц.Нямдорж<br>Аймаг,нийслэлийн Засаг дарга |
| | | | 5. Мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх асуудлаар жил тутам нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулан дүгнэж байна. | 2005 оноос жил бүр | Ц.Нямдорж<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 6. Архидан согтуурахтай тэмцэх сан, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх санг дэмжих арга хэмжээ авч, сангуудыг дэмжих бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ. | 2005 | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | | | 7. Мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загвар боловсруулж мөрдүүлнэ. | 2004-2005 | Д.Тэрбишдагва<br>И.Эрдэнэбаатар |
| | | | 8. Малын хулгайтай тэмцэх асуудлаар бүсчилсэн семинарыг хоёр жил тутамд зохион байгуулна. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Д.Тэрбишдагва, |
| | | | 9. Наркологийн төвийг бие даалган, эрүүлжүүлэх албад болон сайн дурын эмчилгээ, хордлого тайлах төв зэргийг нэгдсэн удирдлагатай болгох, Мааньт дахь албадан эмчилгээний газрыг өргөтгөх, аймаг дундын албадан эмчилгээний газруудыг бий болгох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжинэ. | 2005-2008 | Т.Ганди<br>Ц.Нямдорж |
| | | | 10. Малын хулгай болон архидалттай тэмцэх чиглэлээр зохиож байгаа ажлыг жил тутам дүгнэн мэдээлж байна. | 2005-2008 | Ц.Нямдорж |
| | | | 11. "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлтэд тавих хяналтыг сайжруулна. | 2005-2008 | Д.Тэрбишдагва<br>И.Эрдэнэбаатар |
| **8.2. Улсын хил хамгаалалтын чадавхийг бэхжүүлж хүн хүч, техник, технологи, санхүүгийн хүчин чадлыг сайжруулж, аюулгүй байдлыг хамгаалах тусгай байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:** | | | | | |
| 359 | 8.2.1 | Хил хамгаалалтын ажилд онцгой анхаарал хандуулж, "Дархан хил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор "Дархан хил" хөтөлбөр боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| 360 | 8.2.2 | Хил хамгаалах хүчний техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. | 1. Хилийн харуулын мотоцикл, заставын суудлын авто машин, отряд, ангиудын тээврийн авто машины хангалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | 2005–2008 | Ц.Нямдорж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 361 | 8.2.3 | Хилийн зөрчил, малын хулгай ихтэй хилийн хэсэгт хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлнэ. | 1. Хөвсгөл аймгийн ОХУ-ын Тува улстай хиллэдэг хэсэгт хилийн комендатур-1, хилийн застав 2-ыг нэмж байгуулна. | 2005- 2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Буянт-Ухаа олон улсын хилийн шалган нэвтрүүлэх боомтын барилга барьж, ашиглалтад оруулна. | 2007 | Ц.Нямдорж |
| | | | 3. Хөрш орнуудтай хилийн асуудлаар хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, хилийн асуудлыг шуурхай зохицуулах зорилгоор БНХАУ-ын Хөх хотод хилийн албан ёсны төлөөлөгч суулгах, ОХУ-ын Кызылийн консулын орон тоонд хилийн мэргэжлийн ажилтан ажиллуулна. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил |
| 362 | 8.2.4 | Хил хамгаалалтад сансрын холбоо, тоон мэдээллийн технологийг өргөн ашиглана. | 1. Тал хээрийн болон говийн бүсийн хилийн отряд, заставуудыг радио релейний холбоогоор холбоожуулна. | 2005–2007 | Ц.Нямдорж<br>С.Баярцогт |
| | | | 2. Зарим отрядуудыг Улаанбаатар хоттой "Весат" системийн холбоогоор холбоно. | 2006–2007 | Ц.Нямдорж<br>С.Баярцогт |
| 363 | 8.2.5 | Хил хамгаалагчдын шилжилт хөдөлгөөн хийх чадварыг эрс нэмэгдүүлж, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. | 1. Уулархаг болон усан хилтэй отряд, заставуудыг цасны моторт чарга, хөвөгч завь, хүн нэг бүрийн аврах хэрэгслээр хангана. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Баян-Өлгийн Цагааннуур, Сэлэнгийн Алтанбулагийн боомтуудыг дохиоллын хамгаалалттай болгоно. | 2005 | Ц.Нямдорж |
| | | | 3. Хилийн боомтуудыг баримт бичгийн хяналт шалгалтын орчин үеийн техник хэрэгслээр хангана. | 2006 | Ц.Нямдорж |
| | | | 4. Замын-Үүдийн хилийн отрядын хэсэгт алс зайнаас дүрс дамжуулах хяналтын байгууламж нэвтрүүлнэ. | 2005–2006 | Ц.Нямдорж |
| | | | 5. Дорнод, Сүхбаатар Дорноговь аймгийн хилийн хэсгийн хашааг шинэчилнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 6. Өмнөд хилийн хэсэгт мөр хянах зурвасыг жил бүр сэргээж, хил хамгаалалтад ашиглана. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| 364 | 8.2.6 | Хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарч, хилчдийн ахуй амьдралыг дээшлүүлнэ. | 1. Хилийн цэргийн дээд сургуулийг өргөжүүлж, бүрэлдэхүүнд ахлагч нарын сургууль байгуулж, төрөл бүрийн мэргэжлийн хилчдийг бэлтгэх үйл ажиллагааг нэмэгдүүлнэ. | 2006–2008 | Ц.Нямдорж |
| | | | 2. Хөдөлгөөнт обьектын байрлалыг тодорхойлох GPS системийг нэвтрүүлнэ. | 2005-2006 | Ц.Нямдорж<br>С. Баярцогт |
| | | | 3. Хилийн тагнуулын албыг өндөр мэргэшилтэй боловсон хүчнээр бүрдүүлж, гүйцэтгэх ажлын шинэ техник хэрэгслээр хангана. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 4. Хил хамгаалах байгууллагын боловсон хүчнийг гадаад дотоодын цэргийн академи, их дээд сургуулиудад сургаж, ажиллагсдыг шаталсан сургалтад хамруулж, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>П.Цагаан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5. Хилчдийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, зарим хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авна. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>Ц. Баярсайхан |
| | | | 6. Хилчдийн дүрэмт хувцсыг шинэчилнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 7. Говийн нөхцөлд хатуулаг ихтэй ус хэрэглэж байгаа хилчдийн ундны усыг цэвэршүүлэх арга хэмжээ авна. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 8. Өмнөд хилийн зарим отряд, заставуудын барилга байгууламжид их засвар хийнэ. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| | | | 9. Төв суурин газраас алслагдсан анги, салбарт ажиллагсдын хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах, дотуур байраар хангахад дэмжлэг үзүүлж, Дорнодын Мэнэнгийн отрядад бага сургууль байгуулна. | 2005–2008 | Ц.Нямдорж<br>П.Цагаан |
| | | | 10. Заставын 1 хилчинг 3.5-аас доошгүй унаагаар хангана. | 2005–2008 | Ц.Нямдорж |
| 365 | 8.2.7 | Улсын хил хамгаалалтад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хилийн хязгаар нутагт амьдарч буй иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэхэд тулхүү анхаарна. | 1. Хилийн хязгаар нутагт амьдарч байгаа иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэх ажлыг сайжруулах арга хэмжээ авна. | 2005–2008 | С.Баярцогт<br>П.Цагаан<br>Т.Ганди<br>Аймгийн Засаг дарга |
| 366 | 8.2.8 | Хүний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд терроризм, бусад аюул заналтай тэмцэх талаар олон улсын хэмжээнд тавьж буй хүчин чармайлтыг дэмжиххийн зэрэгцээ үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 1. Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг сайжруулах, терроризмтэй тэмцэх үүрэг бүхий нэгж, бүтцийг бий болгож, тэнд ажиллагсдыг сургаж дадлагажуулна. | 2005–2008 | Б.Эрдэнэбат<br>Ц.Нямдорж ,<br>С.Баярцогт |
| | | | 2. Терроризмтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл солилцох орон тооны бус зохицуулах зөвлөлийг байгуулах, уг зөвлөлийн ажиллах холбогдох эрх зүйн баримт бичгийг батлуулж мөрдүүлнэ. | 2005-2006 | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| 367 | 8.2.9 | Тагнуулын албыг өндөр мэргэшилтэй албан хаагчдаар бүрдүүлэхэд анхаарч, гүйцэтгэх ажилд шинэ техник хэрэгсэл, аргыг нэвтрүүлнэ. | 1. Тагнуулын ерөнхий газрын дээд сургуульд тагнуулын дээд мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэж, ажилтнуудыг магистрын сургалтанд хамруулна. | 2005-2008 | С.Баярцогт |
| | | | 2. Энгийн мэргэжлээр төгссөн шинэ ажилтнуудыг Тагнуулын ерөнхий газрын дээд сургуульд 6 сараас доошгүй хугацаагаар мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээ авна. | 2005-2008 | С.Баярцогт |
| | | | 3. Түншийн харилцаатай гадаадын тусгай албадын дээд сургууль, академийн үндсэн анги болон богино хугацааны сургалтад үндсэн ажилтнуудаас жилд 40 хүнийг сургаж мэргэшүүлнэ. | 2005-2008 | С.Баярцогт |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 4